



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛИЙГ ЗОХИОН
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ
ХУВААРИЛЖ, ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН
ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙХ.

АУДИТЫН КОД: УВА-2025/72-ШТА-НА

Улаангом хот 2025 он

Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь

Утас: 70453317 Цахим хаяг: batsuurnm@audit.gov.mn

Аудитын менежер М.Бат-Амгалан

Утас: 70453317 Цахим хаяг: batamgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Мөнхтогтох

Утас: 70453317 Цахим хаяг: munkhtogtokhch@audit.gov.mn

Аудитор А.Нанжидмаа

Утас: 70453317 Цахим хаяг: nanjidmaaa@audit.gov.mn

Аудитор Т.Золоо

Утас: 70453317 Цахим хаяг: zoloot@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
Open_audit.mn хаягаар авна уу.

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	4
Аудитын менежер М.Бат-Амгалан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-6
Ахлах аудитор Ч.Мөнхтогтох	Бүлэг 1. Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан байна.	7
Аудитор Т.Золоо А.Нанжидмаа	1.1. Сонгуулийн хороонд зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.	7-8
2025 оны 07 дугаар сар	1.2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.	8-9
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг 2. Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахад зориулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж 3,344.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.	9
	2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 3,344.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.	9-10
	2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.	10
	2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн байна.	11
Хаяг: Увс аймаг дахь Төрийн Аудитын газар Улаангом сум 3 баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Дүгнэлт	12
	Холбогдох байгууллагын санал	13
	Аудитын газраас өгөх тайлбар	

Товчилсон үгийн тайлал:

УВА	Увс аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ГНАГ	Гүйцэтгэл нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
МТБ	Мэдээлэл технологийн баг

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10, 10.11 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2025 оны А/44 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгох санхүүжилтийг зөв төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт, гүйцэтгэлийг зөв тайлагнасан эсэх.

Хамарсан хүрээ

Аудитыг аймгийн Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Баруунтуруун сумын сонгуулийн хорооны баримт материалыг хамруулан хийж гүйцэтгэлээ.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх зэрэг арга зүйг ашигласан.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

- Төрийн аудитын тухай хууль,
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Нийгмийн даатгалын тухай хууль,

- ХХОАТ-ын тухай хууль,
- Холбогдох бусад хууль, эрх зүйн актууд

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Ч.Мөнхтогтох, аудитор А.Нанжидмаа, Т.Золоо нар гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийг Баруунтуруун сумын 1 мандат, 1 хэсгийн хороотойгоор зохион байгуулсан байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой аймгийн Сонгуулийн хороонд 43,195.2 мянган төгрөгийн төсөв олгосон байна.

БҮЛЭГ: 1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан байна.

1.1. Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.1-д “Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна” гэж заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 3/273 дугаар тушаалаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн санхүүжилтийн хуваарийг гаргаж Увс аймгийн Сонгуулийн хороонд 43,195.2 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.

Журмын 2.2-д “Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардал хуваарилна” гэж заасны дагуу хуваарилж ирүүлсэн байна. Үүнд:

		/мян.төг/
№	Зардлын нэр	Хуваарилсан төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх	77.0
2	Сургалтын зардал	1,425.0
3	Бичиг хэрэг	450.0
4	Шуудан холбоо	700.0
5	Унааны зардал	1,360.0
6	Санал авах байр бэлтгэх	300.0
7	Сурталчилгааны зардал	700.0
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх ачаа, томилолт	9,910.4
9	МТБ-ийн гишүүний холбоо, унаа	500.0
10	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах	140.0
11	Сонгуулийн хорооны урамшуулал, хоол	17,852.8
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоол	3,404.8
13	Томилолтын зардал	4,655.2
14	Шуурхай багийн зардал	1,720.0
	ДҮН	43,195.2

Эх сурвалж: /Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын тушаал/

Журмын 2.3-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн тайлбар, аргачлал, байгуулагдсан сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах гишүүдийн тоог харгалзан сум, дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах байдлаар хуваарилна” гэж заасны дагуу Увс аймгийн Сонгуулийн хорооны даргын “Санхүүжилт хуваарилах тухай” 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар захирамжаар хуваарилсан байна. Үүнд:

		/мян.төг/
№	Зардлын нэр	Хуваарилсан төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх	77.0
2	Бичиг хэрэг	150.0
3	Шуудан холбоо	200.0
4	Унааны зардал	960.0
5	Санал авах байр бэлтгэх	300.0
6	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх ачаа, томилолт	490.0
7	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглах зардал	140.0
8	Томилолтын зардал	660.0
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	400.0
10	Урамшуулал, хоолны зардал, нийгмийн даатгал шимтгэл	9,172.8
11	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал	1,635.2
	ДҮН	14,185.0

Эх сурвалж: /Аймгийн сонгуулийн хорооны даргын захирамж /

1.2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой төрийн захиргааны байгууллага төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

10.2.1.сонгогчийг бүртгэх, түүнийг таньж оруулах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээг хийх, тээвэрлэх, даатгал хийлгэх зардал, лицензийн төлбөр;

10.2.2.сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, түүнийг цахим хуудаст байршуулах, хэвлэх, хүргэх, мэдээлэл, сурталчилгаа явуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал;

10.2.3.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, холбоо, унаа, томилолтын зардал;

10.2.4.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны сургалт зохион байгуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал;

10.2.5.сонгогчийг бүртгэх техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын ажилтны томилолт, унааны зардал, техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий мэдээллийн технологийн шуурхай багийн ажилтны мөнгөн урамшуулал, хоолны зардал;

10.2.6.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;

10.2.7.сонгуулийг зохион байгуулахтай холбогдон гарах бусад зардал.

Дээрх заалтын дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/82 дугаар тушаалаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулах зардлын төсөв”-ийг төлөвлөж баталсан байна. Үүнд:

№	Зардлын нэр	/мян.төг/ Хуваарилсан төсөв
1	Мөнгөн урамшуулал	1,386.1
2	Дотоод албан томилолт	554.0
3	Тээвэр шатахуун	337.4
4	Бусад хангамж	50.0
	ДҮН	2,327.5

Эх сурвалж: /Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал/

БҮЛЭГ: 2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахад зориулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 3,344.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 3,344.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 3/273 дугаар тушаалын хавсралтаар аймаг, сумын сонгуулийн хороонд хуваарилсан 43,195.2 мянган төгрөгийн төсвийн зарцуулалтыг зардлын зүйл ангиллаар харуулбал дараах байдалтай байна.

№	Зардлын нэр	Аймгийн нийт дүнгээр		
		Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	77.0	77.0	-
2	Сургалтын зардал	1,425.0	1,429.9	0.1
3	Бичиг хэргийн зардал	450.0	450.0	-
4	Шуудан холбооны зардал	700.0	700.0	-
5	Унааны зардал	1,360.0	1,360.0	-
6	Санал авах байр бэлтгэх зардал	300.0	300.0	-
7	Сурталчилгааны зардал	700.0	-	700.0
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх ачаа, томилолтын зардал	9,910.4	9,784.4	126.0
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	500.0	500.0	-
10	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	140.0	140.0	-
11	Шуурхай багийн зардал	1,720.0	710.0	1,010.0
12	Томилолтын зардал	4,655.2	4,115.3	539.9
13	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	17,852.8	16,900.8	952.0
14	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоол, НДШ	3,404.8	3,388.0	16.8
	Зарцуулалтын дүн	43,195.2	39,850.4	3,344.8
	Сум төвлөрүүлсэн дүн	0	0	0
	Аймаг төвлөрүүлсэн дүн		3,344.8	0.0

Эх сурвалж: /Аймаг, сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримт/

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахад зориулан улсын төсвөөс олгосон 43,195.2 мянган төгрөгөөс 39,850.4 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 3,344.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/82 дугаар тушаалын хавсралтаар 2,327.5 мянган төгрөгийг Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсныг дараах байдлаар зарцуулсан байна.

Зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна

№	Зардал	Төсөв	Гүйцэтгэл	/мян.төг/
				Үлдэгдэл
1	Мөнгөн урамшуулал	1,386.1	1,386.1	0.0
2	Дотоод албан томилолт	554.0	522.0	32.0
3	Тээвэр шатахуун	337.4	334.0	3.4
4	Бусад хангамж	50.0	85.4	-35.4
Нийт дүн		2,327.5	2,327.5	0.0

Эх сурвалж: /Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн баримт/

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн урамшуулалд 1,386.1 мянга, дотоод албан томилолтын зардалд 522.0 мянга, тээвэр шатахууны зардалд 334.0 мянга, бусад хангамжийн зардалд 85.4 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Увс аймаг дахь Цагдаагийн газарт сонгуулийн зардал хуваарилагдаж ирээгүй байна.

2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.4-д “Сум, дүүргийн сонгуулийн хорооны болон салбар комиссын дарга, нягтлан бодогч нар 4.3-т заасан тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор гарган, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын дарга, нягтлан бодогч нар энэ журмын 4.3-т заасан тайланг нэгтгэн 4.2-т заасны дагуу нэгдсэн тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж Сонгуулийн ерөнхий хороонд тус тус хүлээлгэн өгнө”, 4.5-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нэгдсэн тайланг аймаг, нийслэлийн аудитын байгууллагаар хянуулан дүгнэлт гаргуулсан байна” гэж заасан байна.

Сонгуулийн хорооны ирүүлсэн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

/мян.төг/				
Д/д	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Баруунтуруун	14,185.0	14,185.0	0
2	Аймаг	29,010.2	25,665.4	3,344.8
	Нийт дүн	43,195.2	39,850.4	3,344.8

Эх сурвалж: /Аймаг, сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримт/

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.9-д “Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлнэ” гэж заасны дагуу аймгийн Сонгуулийн хороо 3,344.8 мянган төгрөгийн үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд төвлөрүүлсэн байна.

2.3. Сонгуулийн зардлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тайлбарыг Сонгуулийн хорооны Тамгын газрын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 3/273 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тайлбарыг аймгийн Сонгуулийн хорооны даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10-д Сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь сум дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасны дагуу аймгийн Сонгуулийн хороо нь сумын Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын гүйцэтгэлд хяналт тавьж сумын сонгуулийн зардлын тайлан, анхан шатны баримтыг аймгаас хуваарилсан зардлын нэгтгэлтэй тулган хүлээн авч хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан байна.
2. Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг журмын дагуу зарцуулсан байна.
3. Зардлын гүйцэтгэлийг журамд заасны дагуу тайлагнасан байна.

Холбогдох байгууллагын санал



УВС АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-2315, Факс: 7045-4095

Цахим шуудан: info@uvs.gov.mn

Цахим хуудас: www.uvs.gov.mn

2025.07.08 № 11

танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.БАТСУУРЬ ТАНАА


Аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Төсөлд тусгах санал байхгүй болно.

ДАРГА  Ч.ЭНХБАЯР



**Холбогдох байгууллагын ирүүлсэн
саналд өгөх тайлбар**

Увс аймгийн Сонгуулийн хорооны даргын 2025 оны 07 дугаар сарын 08-ны
өдрийн 11 дүгээр албан бичгээр тайлангийн төсөлтэй санал нэг байна гэсэн хариу
ирүүлсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:АХЛАХ АУДИТОР:
АУДИТОР:Ч.МӨНХТОГТОХ
Т.ЗОЛОО
А.НАНЖИДМАА**ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР:



М.БАТ-АМГАЛАН

